



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/876

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10, 7 дугаар зүйлийн 7.3-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

2.Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг холбогдох төсвийн саналын хамт 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн дотор боловсруулан батлуулж, өндөр хэмжээнд зохион байгуулж ажиллахыг нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаад даалгасугай.


3.Нийслэлийн өдрийг угтан харьяа нутаг дэвсгэр, байгууллагын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг энэ захирамжийн 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөтэй уялдуулан баталж, батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхийг дүүргүүдийн Засаг дарга нарт болон харьяа байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

Нийслэлийн Засаг даргын 2018 оны
...09...сарын 18...-ны өдрийн
А.С.Г.Г. захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч -Нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч
- Дэд ахлагч -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Гишүүд:
- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /зөвшилцсөнөөр/;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга;
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны тасгийн дарга;
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга;
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга;
 - Нийслэлийн Цагдаагийн газрын дарга;
 - Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга;
 - Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;
 - Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны дарга;
 - Нийслэлийн Архивын газрын дарга;
 - Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга;

- Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;
- Нийслэлийн Боловсролын газрын дарга;
- Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;
- Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга;
- Тээврийн цагдаагийн албаны Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газрын дарга;
- Баянгол дүүргийн Засаг дарга;
- Баянзүрх дүүргийн Засаг дарга;
- Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;
- Сүхбаатар дүүргийн Засаг дарга;
- Хан-Уул дүүргийн Засаг дарга;
- Чингэлтэй дүүргийн Засаг дарга;
- Налайх дүүргийн Засаг дарга;
- Багануур дүүргийн Засаг дарга;
- Багахангай дүүргийн Засаг дарга;
- “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын дарга;
- “Соёлын төв өргөө”-ний захирал;
- “Монголын Хүүхдийн ордон”-ы захирал;
- “Улаанбаатар хотын музей”-н захирал;
- Нарийн бичгийн дарга -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга.

---oOo---